



**БЭРС ФИНАНС**

Банк Бус Сангүүгийн Байгууллага

БЭРС ФИНАНС ББСБ ХХК -ИЙН  
**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**2025**



## АГУУЛГА

---

- 1** Компаний танилцуулга;
- 2** Онцлох үйл явдал;
- 3** Санхүүгийн үр дүн;
- 4** Зохистой харьцааны үзүүлэлт;
- 5** Эрсдэлийн удирдлага;
- 6** Хүний нөөцийн онцлох үр дүнгүүд;
- 7** Гүйцэтгэх удирдлагын баг;
- 8** ТУЗ-ын бүрэлдхүүн, үйл ажиллагаа;

## КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

“Бэрс Финанс ББСБ” ХХК нь 2017 оны 5 дугаар сарын 18-нд үүсгэн байгуулагдаж, зээлийн болон факторингийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Өдгөө нийт 20 салбартайгаар үйл ажиллагаа явуулж, үүнээс 2 салбар нь Улаанбаатар хотод, 18 салбар нь орон нутагт байрлан санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэн ажиллаж байна. Манай удирдлагын баг нь банк, санхүүгийн салбарт 10–30 жилийн туршлагатай мэргэжлийн хамт олноос бүрддэг.

### ЭРХЭМ ЗОРИЛГО

Харилцагчийнхаа санхүүгийн чадавхийг нэмэгдүүлж хамт олон хүртээмжтэй байдлаар ялгарсан хүчирхэг компани байна.

### АЛСЫН ХАРАА

Санхүүгийн цогц шийдлийг хүн бүрт хүргэх замаар нийгэмд эерэг өөрчлөлтийг түгээнэ.

Багийн сэтгэлгээ

Ёс зүй,  
хариуцлага

Хамтын өгөөж

Мэргэжлийн ур  
чадвар


**20**  
салбар

**105**  
ажилтан

**42,000**  
харилцагч




# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



## BERS PAY АППЛИКЕЙШН ХЭРЭГЛЭЭНД НЭВТЭРЛЭЭ

BERS Pay аппликейшн нь харилцагчдын санхүүгийн үйлчилгээг хурдан, хялбар авах боломжийг бүрдүүлсэн дижитал шийдэл юм. Хэрэглэгчид зээл, итгэлцэл зэрэг үйлчилгээг салбар дээр очихгүйгээр, гар утсаараа шууд авах боломжтойгоороо цаг хэмнэж байна.

Тус аппликейшн нь аюулгүй, найдвартай байдлыг хангасан нэвтрэх системтэй бөгөөд харилцагчдыг хаанаас ч, хэзээ ч санхүүгийн үйлчилгээгээ итгэлтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлж байна.



## 29 ТЭРБУМ ТӨГРӨГИЙН ХБҮЦ

Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг 2022 оноос эхлэн гаргаж байна. 2025 онд 4 дахь удаагийн буюу Бэрс 4.0 ХБҮЦ-ыг амжилттай гаргаж, 29 тэрбум төгрөгийг арилжааны цонх нээгдсэнээс хойш 80 минутад татан төвлөрүүлсэн нь манай байгууллага хөрөнгийн зах зээлд харилцагчдынхаа итгэлийг хүлээсэн байгууллага болж чадсаныг харуулж байна.

“Bers ABS pro” ТЗК нь нийт 24 сарын хугацаатай 19.5 хувийн хүүтэй, хагас жил тутам үндсэн төлбөрийг тэнцүү хуваан төлж, улирал тутамд хүү төлөх нөхцөлтэй гаргасан билээ.



## ISO/IEC 27001:2022, ISO/IEC 27001:2023 СТАНДАРТ НЭВТРҮҮЛЭВ

Бэрс Финанс ББСБ ХХК нь ISO/IEC 27001:2022, ISO/IEC 27001:2023 “МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТ”-ыг нэвтрүүлээ.

Мэдээллийн аюулгүй байдлын аудитыг Монголын Үндэсний итгэмжлэлийн төвд бүртгэлтэй ABS Certification LLC хийж, Энэтхэгийн SIS Certification PVT Ltd сертификатыг олгон, “Бэрс Финанс” ББСБ олон улсад итгэмжлэгдсэн байгууллага боллоо. Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог хэрэгжүүлэх төслийн зөвлөхөөр ProActive Solutions компанийн мэргэшсэн зөвлөхүүд хамтран ажиллалаа.



## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



### НИЙСЛЭЛИЙН ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТӨВ /НӨҮГ/-ТЭЙ ХАМТЫН АЖИЛЛАГАА ЭХЛҮҮЛЭВ

2025 оны 6 дугаар сарын 23-ны өдөр BERS Finance нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжин ажиллахаа илэрхийлж, Нийслэлийн Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих төвтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Энэхүү хамтын ажиллагаа нь ЖДҮ эрхлэгчдэд чиглэсэн санхүүгийн дэмжлэг, хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

Санамж бичгийн хүрээнд Улаанбаатар хот төдийгүй орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй бизнес эрхлэгчдэд санхүүгийн илүү хүртээмжтэй, уян хатан шийдлийг санал болгох боломж бүрдэж байна.



### FAMILY SUPPORTIVE – ГЭР БҮЛД ЭЭЛТЭЙ ШИЛДЭГ АЖИЛ ОЛГОГЧ

Монгол Улсын хэмжээнд ажил олгогч байгууллагуудын ажлын орчин, хүний нөөцийн бодлого, ажилтны хөгжлийг дэмжих шилдэг туршлагыг тодруулдаг “Good Workplace Awards 2025” үндэсний арга хэмжээ амжилттай зохион байгуулагдсан. Тус арга хэмжээ нь байгууллагуудын ажилтанд ээлтэй орчин, тогтвортой хүний нөөцийн менежментийг дэмжих зорилготой юм. Энэхүү арга хэмжээний хүрээнд “Бэрс Финанс ББСБ ХХК” нь гэр бүлд ээлтэй, ажилтанд чиглэсэн хүний нөөцийн бодлого, байгууллагын соёлоороо онцгойлон үнэлэгдэж, “Family Supportive – Гэр бүлд ээлтэй шилдэг ажил олгогч байгууллага” шагналын эзэн боллоо.



### “НҮҮДЭЛЧИН 2025” ОЛОН УЛСЫН ФЕСТИВАЛЬ

2022 оноос хойш зохион байгуулагдаж буй олон улсын НҮҮДЭЛЧИН фестивалд BERS Finance оролцож, фестивалийн өдрүүдэд жижиг, дунд үйлдвэрлэл болон эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулж, зээлийг газар дээр нь олгон ажиллалаа.

Тус фестивалд 21 аймаг болон нийслэлийн бүх дүүргийн урлаг, соёлын байгууллагууд, мөн олон тооны жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид оролцож, өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үзэсгэлэн худалдаа, танилцуулгыг зохион байгуулсан юм



## ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



### ХАМТЫН АЖИЛЛАГАА

Өвөрхангай, Баян-Өлгий, Сүхбаатар, Хөвсгөл, Увс салбарууд тухайн аймгуудын Худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Энэхүү хамтын ажиллагаа нь орон нутгийн бизнесийн орчныг дэмжих, харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэж байна.



### ХОВД САЛБАР 2025 ОНЫ ХОВД АЙМГИЙН ШИЛДЭГ ББСБ-ААР ШАЛГАРЛАА

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын уламжлалт шалгаруулалтын хүрээнд Бэрс Финанс ББСБ ХХК-ийн Ховд салбар нь Ховд аймгийн “Шилдэг аж ахуй нэгж байгууллага”-аар тодорлоо.

Үүний үр дүнд тус салбар нь 2025 оны Ховд аймгийн “Шилдэг банк бус санхүүгийн байгууллага” хэмээх нэр хүндтэй үнэлгээг хүртэж, орон нутгийн хөгжилд оруулж буй бодит хувь нэмрээ бататгалаа. Энэхүү амжилт нь харилцагч төвтэй үйлчилгээ, тогтвортой үйл ажиллагааг албан ёсоор үнэлсэн явдал юм.



### АЖИЛТНУУДЫН ГАДААД АЯЛАЛ

Хамт олноо урамшуулах, шилдэг гүйцэтгэлийг дэмжих бодлогын хүрээнд бусдадаа түүчээ болсон салбарууд болон ажилтнуудаа тогтмол урамшуулдаг уламжлалтай. Энэ жилийн хувьд ажлын амжилтаараа манлайлсан 9 салбарын 24 ажилтныг сонгон, Вьетнам улсын Дананг хотод 8 өдөр, 9 шөнийн аяллаар урамшуулж, хамт олны идэвх, сэтгэл ханамжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодит дэмжлэг үзүүлээ.




## САНХҮҮГИЙН ҮР ДҮН


### Эх үүсвэрийн бүтэц (тэрбум төгрөг)




### Хөрөнгийн бүтэц (тэрбум төгрөг)




### Зээлийн чанар (хувь)



### Компанийн ашигт ажиллагаа (хувь)



### Зээлийн багцын өсөлт (хувиар)



## ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Д/д	Зохистой үзүүлэлт	Байвал зохих	Хангасан эсэх
<b>А.</b>	<b>Өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт</b>		
<b>1</b>	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-аас доошгүй	Хангасан
<b>2</b>	Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-аас доошгүй	Хангасан
<b>3</b>	Өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа:	30%-аас доошгүй	Хангасан
<b>Б.</b>	<b>Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа</b>		
<b>4</b>	Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-аас дээш	Хангасан
<b>В.</b>	<b>Актив хөрөнгийн төвлөрлийн үзүүлэлт</b>		
<b>5</b>	Хөрөнгө /актив/-ийн эрсдэлийн сангийн хүрэлцээ (+Илүү,-Дутуу )	1,343,751,222.5	(0.0)
<b>6</b>	Нэг зээлдэгч болон холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	Хангасан
<b>7</b>	Ббсб-аас гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	70%-аас хэтрэхгүй	-
<b>8</b>	Ббсб-ын хувьцаа эзэмшигч, туз, гүйцэтгэх захирал ажилтан холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны нийлбэр дүнгийн зохистой харьцаа	25%-аас хэтрэхгүй	Хангасан
<b>9</b>	Ббсб-ын хувьцаа эзэмшигч, туз, гүйцэтгэх захирал ажилтан, холбогдох нэг этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгө, төлбөрийн баталгааны зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	Хангасан
<b>10</b>	Үнэт цаасны эзэмшил өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	50%-аас хэтрэхгүй	Хангасан
	Компанийн хувьцаа, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	Хангасан
	Монголын хөрөнгийн биржийн "i", "ii" ангилалын нэг компанийн гаргасан хувьцаанаас худалдаж авах зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	-
	Компанийн өрийн бичиг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	20%-аас хэтрэхгүй	Хангасан
	Бусад үнэт цаас, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	10%-аас хэтрэхгүй	-
<b>Г.</b>	<b>Гадаад валютын ханшийн эрсдэл</b>		
<b>11</b>	Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	(+/-40%)	Хангасан
<b>Д.</b>	<b>Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн үзүүлэлтүүд</b>		
<b>12</b>	Итгэлцлийн үйлчилгээний өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	60%-аас хэтрэхгүй	Хангасан
<b>13</b>	Итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн нөөц сан	415,484,524.6 3,333,545,696.9	Хангасан
<b>18</b>	Өрийн бичгийн зохистой харьцаа	30%-аас хэтрэхгүй	Хангасан
<b>Е.</b>	<b>Үндсэн хөрөнгийн үзүүлэлт</b>		
<b>17</b>	Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-аас хэтрэхгүй	Хангасан
<b>Ж.</b>	<b>Өгөөж</b>		
<b>19</b>	Хөрөнгө /актив/-ийн өгөөж	11.4%	
<b>20</b>	Өөрийн хөрөнгийн өгөөж	26.5%	

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

“Бэрс Финанс ББСБ” ХХК нь үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах зорилгоор эрсдэлийн удирдлагын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна. Уг тогтолцооны хүрээнд бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй эрсдэлийг тодорхойлж, үнэлэн, хянах, бууруулах болон хүлээн зөвшөөрөх зохистой түвшинг тогтоон мөрдөж, компанийн стратеги, дотоод журам, хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлдэг.

Компанийн эрсдэлийн удирдлага нь “Хамгаалалтын гурван бүс”-ийн зарчимд тулгуурладаг. Үүнд:

Нэгдүгээр бүс – Үйл ажиллагааны нэгжүүд өдөр тутмын эрсдэлийг тодорхойлж, хянаж, бууруулна;

Хоёрдугаар бүс – Эрсдэлийн удирдлага, бодлогын нэгжүүд бодлого, журмыг боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавина;

Гуравдугаар бүс – Дотоод аудит эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны үр нөлөөг хараат бусаар үнэлж, сайжруулах зөвлөмж өгнө.

### Дотоод аудитын үйл ажиллагаа

Дотоод аудитын нэгж нь 2025 онд байгууллагын дотоод хяналтын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах зорилгоор нийт хэсэгчилсэн 8 аудит, иж бүрэн 2 аудит болон гадны аудитын компанитай хамтран хэрэгжүүлсэн иж бүрэн аудит-ыг тус тус гүйцэтгэсэн.


Мөн Улаанбаатар хот болон орон нутгийн 6 салбарт төлөвлөгөөт аудит хийж, аудитын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр холбогдох салбар болон төвийн нэгжүүдэд үүрэг, даалгавар өгч, тэдгээрийн хэрэгжилтэд эргэн хяналт хийж ажилласан байна.

### Мэдээллийн аюулгүй байдал

Мөн 2025 онд Бэрс Финанс ББСБ ХХК нь байгууллагын мэдээллийн нөөц, харилцагчийн мэдээлэл болон санхүүгийн өгөгдлийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангах зорилгоор Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо (ISMS)-г нэвтрүүлсэн.

Уг тогтолцоог нэвтрүүлэх хүрээнд олон улс болон Монгол Улсад хүлээн зөвшөөрөгдсөн ISO/IEC 27001 мэдээллийн аюулгүй байдлын стандартын шаардлагыг бүрэн хангаж, хараат бус, эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаар аудит хийлгэн, ISO/IEC 27001 стандартын 2 гэрчилгээг гардан авсан байна.

# ХҮНИЙ НӨӨЦИЙН ОНЦЛОХ ҮР ДҮНГҮҮД



Нийт ажилтны тоо

**105**



Хүний нөөцийн эргэц

**1.3%**



Дундаж нас

**32**



## GLOBAL HR FORUM

2006 оноос эхлэн БНСУ-ын KRIVET, Боловсролын яам, Korea Economic Daily зэрэг байгууллагуудын хамтран зохион байгуулж ирсэн Global HR Forum нь хүний нөөцийн салбарын олон улсын чухал арга хэмжээ юм.

2025 оны форум “The Era of Symbiotic Intelligence” сэдвийн дор зохион байгуулагдсан бөгөөд Бэрс Финанс тус арга хэмжээнд оролцсоноор хүний нөөцийн удирдлагад хиймэл оюун ухаан, хүний оюун ухааны уялдаа холбоотой холбоотой олон улсын чиг хандлагыг судлах боломж бүрдүүлээ

### Ажлын богиногосон цаг

**09:00-16:00**

Бэрс Финанс ББСБ ХХК нь ажилтнуудын ажил, амьдралын тэнцвэрийг дэмжих зорилгоор 7 цагийн ажлын цагийн зохицуулалт нэвтрүүлсэн бөгөөд салбарын ажилтнуудын 96 хувь нь 09:00-16:00 цагийн хооронд 6 цагийн ажлын хуваариар ажиллаж байна.

### Ажилтны хөнгөлөлттэй зээл

**1 тэрбум.төг**

Залуу гэр бүлийг дэмжсэн орон сууц, байр байшин, авто машин худалдан авах жилийн 8% хүүтэй, урт хугацаатай хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөр 2022 оноос эхлэн хэрэгжиж, өнөөдрийн байдлаар 1 тэрбум төгрөгийн зээлийг ажилтнууддаа олгосон байна.

### Үндсэн цалин

**30% нэмэгдэв**

2022 оноос эхлэн жил бүр үндсэн цалинг нэмэх бодлого баримталж, 2025 онд нийт ажилтны цалинг 30 болон түүнээс дээш хувиар нэмэгдүүлээ



## ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ



### ТОС ХОЛБООНЫ ГИШҮҮН БАЙГУУЛЛАГА БОЛОВ

Монголын тогтвортой санхүүгийн холбоо (ТоС Холбоо)-ны 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн Удирдах зөвлөлийн хурлаар Бэрс Финанс ББСБ ХХК-ийн үндсэн гишүүн байгууллагаар элсэх хүсэлтийг баталж, 7 сарын 7-ны өдөр албан ёсоор үндсэн гишүүн байгууллагаар бүртгүүлэв. Энэ хугацаанд ТоС холбооны зарчмуудтай холбогдох үйл ажиллагааг нэвтрүүлж, өмнөх ажлуудыг илүү сайжруулан ажиллав. Жишээлбэл, зээлийн бүтээгдэхүүнд эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжсэн зээлийн бүтээгдэхүүн шинээр нэвтрүүлж, оффис дахь цахилгаан, усны зарцуулалтад хяналт тавин зөв шийдлүүдийг нэвтрүүлж, ногоон зээлийн бүтээгдэхүүн нэвтрүүлэн ажиллаж байна.



### ШИНЭ БҮТЭЭГДЭХҮҮН НЭВТРҮҮЛЭЭ

Зээлийн бүтээгдэхүүний төрлийг солонгоруулж, эмэгтэй бизнес эрхлэгчид болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих шинэ зээлийн бүтээгдэхүүнийг шинээр нэвтрүүллээ. Уг бүтээгдэхүүнүүд нь бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэх, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн онцлог нөхцөлтэй юм.

Шинэ зээлийн бүтээгдэхүүнүүдийг харилцагчдын бодит хэрэгцээнд нийцүүлэн боловсруулсан бөгөөд бизнес эрхлэгчдэд илүү уян хатан, хүртээмжтэй санхүүгийн шийдлийг санал болгож байна.



### ЦӨЛЖИЛТИЙН ЭСРЭГ МОД ТАРИХ АЯН

“Бэрс Финанс ББСБ” ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд 2017 оноос эхлэн жил бүр цөлжилтийн эсрэг мод тарих ажлыг тогтмол хэрэгжүүлж байна. Энэхүү санаачилгын хүрээнд байгаль орчны доройтлыг бууруулах, экосистемийн тэнцвэрийг хадгалах зорилгоор олон бүс нутагт мод тарьж, урт хугацаанд ургах нөхцөлийг бүрдүүлэн ажиллаж байна.

Тухайлбал, Өвөрхангай, Өмнөговь, Төв аймгийн Эрдэнэ сумын газар нутагт мод тарьж, зөвхөн тарилтаар хязгаарлахгүйгээр усалгаа, арчилгааг тогтмол хийж, моддын ургалтыг хангаж ирсэн байна. Ийнхүү BERS Finance нь байгаль орчныг хамгаалах, цөлжилттэй тэмцэх бодитой, үр дүнтэй ажлыг тууштай хэрэгжүүлж байна.

# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



## “ӨНГӨ НЭМНЭ” КАМПАНИТ АЖИЛ

“Бэрс Финанс ББСБ” ХХК нь хүүхдийн сурч, хөгжих орчныг сайжруулах, нийгмийн хариуцлагыг бодитоор хэрэгжүүлэх зорилгын хүрээнд “Өнгө нэмнэ” сайн дурын ажлыг уламжлал болгон зохион байгуулж байна. Энэ жил “Аймагтаа өнгө нэмнэ” уриан дор тус санаачилгыг улс орон даяар 21 аймагт амжилттай хэрэгжүүллээ.

Гурав дахь жилдээ зохион байгуулж буй энэхүү сайн дурын ажлын хүрээнд хүүхдийн цэцэрлэг, сургууль, парк зэрэг олон нийтийн байршлуудад орчны өнгө үзэмжийг сэргээн сайжруулж, хүүхдүүдийн тоглох, суралцах орчныг илүү аюулгүй, өнгөлөг, тав тухтай болгоход бодит хувь нэмэр оруулсан юм.



## “АМЬДРАЛ БЭЛЭГЛЭЭ” ЦУС ХАНДИВЛАХ АЯНД НЭГДЛЭЭ

Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбооноос зохион байгуулдаг “Амьдрал бэлэглээ” цус хандивлах аянд Бэрс Финанс ББСБ ХХК төвийн нэгж болон орон нутаг дахь салбаруудаараа дамжуулан нэг өдөр зэрэг идэвхтэй нэгдлээ. 2025 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр төвийн нэгж болон Улаанбаатар салбарын хамт олон цус хандивлаж, эрдэнэт хүний амь насыг аврах үйлсэд хувь нэмэр оруулсан бөгөөд уг сайн дурын аяныг орон нутгийн салбарууд ч мөн дэмжин хэрэгжүүлж байна.



## ЗУРШИЛААС ХЭВШИЛ РҮҮ” АЯН

Жил бүрийн Цагаан сарын баярыг угтан Улаанбаатар хот болон аймаг бүрийн салбаруудаараа дамжуулан нэгэн зэрэг орчны их цэвэрлэгээ зохион байгуулж, салбар бүр орчмын 300 метр хүртэлх талбайг цэвэрлэн, бусад байгууллага, иргэдэд уриалга хүргэн ажиллаж байна.

“Зуршлаас хэвшил рүү” аяны хүрээнд Бэрс Финанс ББСБ ХХК-ийн 200 гаруй залуус 37 байршилд нэгэн зэрэг нэгдэн гаднах орчны их цэвэрлэгээг хийж, хог хаягдлыг цэвэрлэлээ. Өнгөрсөн жил энэхүү үйл ажиллагаанд ганцхан цагийг зарцуулахад 5 га талбайг цэвэрлэсэн бодит үр дүн гарсан бөгөөд иргэн бүрийн оролцоо нэмэгдвэл цэвэр, аюулгүй орчныг бүрдүүлэх бүрэн боломжтойг онцолж байна.

## ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

Бэрс Финанс ББСБ ХХК-ийн Гүйцэтгэх удирдлагын баг нь компанийн стратеги, Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан бодлого, зорилтыг хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг үр ашигтай, хариуцлагатай зохион байгуулах үндсэн үүрэгтэйгээр ажиллаж байна.

Гүйцэтгэх удирдлагын баг нь өөрийн чиг үүргийн хүрээнд ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороодтой нягт уялдаа холбоотой ажиллаж, батлагдсан стратеги, бодлогын хэрэгжилтийн талаар тогтмол тайлагнан, хяналт-шинжилгээ, үнэлгээг хийлгэн ажиллаж байна.



Гүйцэтгэх захирал

**Г.Юмсүрэн**

14 жилийн туршлагатай



Хөрөнгө  
зохицуулалтын газрын  
захирал

**Я.Адъяахүү**

30+ жилийн туршлагатай



Зээлийн газрын  
захирал

**Ө.Ган-Өлзий**

11 жилийн туршлагатай



Ерөнхий нягтлан  
бодогч

**О.Нямдэлэг**

25 жилийн туршлагатай



Захиргаа, хүний  
нөөцийн ахлах

**У.Ундармаа**

18 жилийн туршлагатай

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Бэрс Финанс ББСБ ХХК-ийн ТУЗ нь хараат бус болон бусад төлөөллийг тэнцвэртэй оролцуулахыг зорьж ажиллаж байгаа бөгөөд бөгөөд компанийн засаглалыг СЗХ-ны журам шаардлага, олон улсын шилдэг туршлагад нийцүүлэн хэрэгжүүлэхийг эрхэмлэн, хяналт, эрсдэлийн удирдлага, ёс зүй, бодлого, журмуудыг тогтмол сайжруулж, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна.

Компанийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангахын тулд хувь нийлүүлэгчид, харилцагчид, хөрөнгө оруулагчид, түнш байгууллагууд, ажилтнууд болон бусад оролцогч талуудтай эрх тэгш хамтран ажиллахыг зорьж байна.

Бэрс Финанс ББСБ-ийн ТУЗ нь 5 гишүүнтэй, үүнээс хараат бус 2 гишүүнтэй.

ТУЗийн дэргэд байгуулагдсан 4 Хороод, үүнд Аудитын Хороо, Нэр Дэвшүүлэх Хороо, Цалин Урамшууллын Хороо, Эрсдэлийн Удирдлагын Хороотой.



ТУЗ-ийн дарга

**Я.Оюумаа**

Санхүүгийн салбарт 15+ жилийн туршлагатай



ТУЗ-ийн гишүүн

**С.Дамдинбазар**

Санхүүгийн салбарт 15+ жилийн туршлагатай



ТУЗ-ийн гишүүн

**Ж. Мөнхсоёмбо**

Санхүүгийн салбарт 15+ жилийн туршлагатай



ТУЗ-ийн хараат бус гишүүн

**П. Гантуул**

Санхүүгийн салбарт 30+ жилийн туршлагатай



ТУЗ-ийн хараат бус гишүүн

**Д. Гантулга**

Бизнесийн салбарт 9 жилийн туршлагатай



# БЭРС ФИНАНС

Банк Бус Сангүүгийн Байгууллага

 **+ 976 7712-2020**  
 **info@bersfinance.mn**  
 **www.bersfinance.mn**